



**НИЙСЛЭЛИЙН АГААРЫН БОХИРДЛЫГ
БУУРУУЛАХ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2016 оны 11 сарын 10 өдөр

Дугаар А/17

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, "Төсвийн тухай" хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Багануурын уурхай, Налайхын нүүрсний орд, Шарын голын уурхай, Шивээ овоогийн уурхай, Алаг толгойн орд газар болон нүүрсний захуудын үйл ажиллагаа, нүүрсний чанар байдалтай танилцаж, агаарын чанарыг сайжруулах бүсэд түүхий нүүрс нийлүүлэхийг хориглох асуудлыг судлан холбогдох албан тушаалтан, байгууллагад танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ахлагч
Гишүүд

Ц.Цолмон /Хэлтсийн дарга/
С.Март /мэргэжилтэн/
Э.Батцэцэг /мэргэжилтэн/
Г.Бат-Оюун /мэргэжилтэн/
Б.Болор /мэргэжилтэн/

2. Тухайн ажлыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж, үр дүнг 2016 оны 11 дүгээр сарын 21-ны дотор танилцуулахыг ажлын хэсэг /Ц.Цолмон/-т даалгасугай.
3. Ажлын хэсгийн томилолтын зардал болох 1 463 300 /нэг сая дөрвөн зуун жаран гурван мянга гурван зуу/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг нягтлан бодогч /Г.Цэрэннадмид/-д зөвшөөрсүгэй.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



М.ДЭЛГЭРЭХ

0500200